



АВТОТЭЭВРИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Итгэн шар зам тань өлзийтэй байх болтуга

СОНГИНОХАЙРХАН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СУДАЛГАА

2023


www.transdep.mn

ᠰᠣᠩᠭᠢᠨᠬᠠᠶᠢᠷᠬᠠᠨ
ᠵᠣᠷᠴᠢᠭᠴᠢ ᠲᠡᠭᠦᠷᠢᠨ ᠲᠡᠪ
ᠤᠯᠢᠴᠢᠯᠠᠭᠴᠢᠨ
ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ᠎ᠠ



Улаанбаатар хот

УДИРТГАЛ



1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийн байршил “Номин худалдааны төв”-ийн байр луу нүүснээр үйлчлүүлэгчдийн аюулгүй үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдсэн эсэх, СХД-ын 29-р хорооны оршин суугчдын амьдрах орчин нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг явуулсан болно.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Сонгинохайрхан зорчигч тээврийн төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч болон СХД-ын 29-р хорооны 23А, 23Б, 23В, 23Г, 24-р байрны оршин суугчдыг судалгаанд хамруулсан.

3 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Сонгинохайрхан зорчигч үйлчилгээний төвөөс үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчийн судалгааг 7 хэмжигдэхүүн бүхий анкетын аргаар, Оршин суугчдын судалгааг Google forms ашиглан цахимаар судалгааны мэдээллийг цуглуулсан болно.

Сэтгэл ханамжийн индексийг тооцохдоо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй болох ServQual model загварыг ашиглан тооцлоо.

НИЙТ ЭХ ОЛОНЛОГ

4

5

Судалгааны түүврийн тоог тогтоохдоо тухайн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 1 өдөрт үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог /2800/ болон оршин суугчдын тоог /750/ тооцоолон эх олонлогоор авлаа.


ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Энд төлөөлөх чадвартай үйлчлүүлэгчийн тоо 339, Оршин суугчийн тоо 110 байна.

Томьёолбол:
$$n = \left(\frac{z(1-\frac{\alpha}{2})^2}{e} \right)$$

Сонгинохайрхан зорчигч тээврийн төв нь “Номин худалдааны төв” рүү нүүснээр үйлчилгээний орчин нөхцөл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж чадаж буй эсэхийг тодорхойлох зорилгоор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс анкетын аргаар судалгаа авсан. Судалгаанд нийт **340** үйлчлүүлэгч хамрагдсан.

1. СОНГИНОХАЙРХАН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВИЙН ОРЧИН НӨХЦӨЛ



1.1 Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийн байршил “Номин худалдааны төв” рүү нүүж ирснээр таны аюулгүй үйлчлүүлэх орчин нөхцөл сайжирсан эсэх.
n=340

Үүнээс **79%** буюу **270** үйлчлүүлэгч **“Тийм”** орчин нөхцөл сайжирсан, 21% буюу 70 үйлчлүүлэгч **“Үгүй”** хэмээн хариулсан байна.

2. ДАРААХ ШАЛГУУР ТУС БҮРИЙН ХУВЬД ҮЙЛ АЖИЛЛАГААГ 1-ЭЭС 5 ОНОО ӨГЧ ҮНЭЛНЭ ҮҮ.

2.1 Хүлээлгийн танхим байгаа эсэхийг оноогоор үнэлнэ үү? n=340

Нийт судалгаанд оролцогчдын **268** буюу **78.8%** нь сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



2.2 Хүлээлгийн танхимын цэвэр тохилог байдлыг оноогоор үнэлнэ үү? n=340



Нийт судалгаанд оролцогчдын **274** буюу **80%** нь сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.




ҮЙЛЧЛҮҮЛЭГЧЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН




2.3 Ариун цэвэрийн өрөөний хүрэлцээг оноогоор үнэлнэ үү. n=340

Нийт судалгаанд оролцогчдын **227** буюу **66.7%** нь сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



2.4 Үйлчлүүлэгчдийн машины зогсоолын хүрэлцээ, зохион байгуулалт. n=340




Нийт судалгаанд оролцогчдын **321** буюу **94.6%** нь сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



2.5 Гадна орчин нөхцлийн аюулгүй байдал. n=340

Нийт судалгаанд оролцогчдын **258** буюу **75.8%** нь сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



3. САНАЛ, ХҮСЭЛТ

Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн **25%** буюу **84** үйлчлүүлэгч санал хүсэлт ирүүлсэн байна. Үүнд:





3.1 Орчин нөхцлийн талаар үйлчлүүлэгчдийн ирүүлсэн санал. *Ихит санал, хүсэлт ирүүлсэн 84 үйлчлүүлэгчийн саналаас тооцсон болно.*




- Хүн орж гарах хаалга ганцхан болохоор хэцүү байна - 20 үйлчлүүлэгч
- Гадна торон хашааг буулгах тойрч гарахад хэцүү ачаа бараагаа холуур зөөхөд хэцүү байна - 12 үйлчлүүлэгч
- Ирэх явах түгжрэлээ л зохицуулмаар байна - 10 үйлчлүүлэгч
- Зорчих хөдөлгөөний чөлөөтэй замын урсгалыг нэмэх - 8 үйлчлүүлэгч
- Машин ордог хэсгийг томруулах үүдэнд түгжрэл их үүсч байна бусдаар сайн гоё болсон. - 6 үйлчлүүлэгч
- Гарах орох явган хүний хашааны гарц их муу - 5 үйлчлүүлэгч
- Таксигаа нэг газар зогсоох - 5 үйлчлүүлэгч
- Гарах чигийн замын эгнээг нэмэх - 4 үйлчлүүлэгч
- Хөдөлмөрийн чадваргүй хүний болон ачааны түрдэг тэрэг хүрэлцээтэй болгох - 3 үйлчлүүлэгч
- Урд хашаан дундуур 2-3 хаалга гарц гаргах - 3 үйлчлүүлэгч
- Хотын төвөөс хэт хол байршилтай байна - 2 үйлчлүүлэгч
- Нүүлгэсэн нь маш буруу - 2 үйлчлүүлэгч
- Аль болох хотын захад байх. - 1 үйлчлүүлэгч
- Аль аймаг явах автобус тодорхой зогсоолтой болмоор санагдлаа баярлалаа - 1 үйлчлүүлэгч
- Эргэн тойрон барилга худалдааны төв барихгүй байх - 1 үйлчлүүлэгч



3.2 Аюулгүй байдал, мэдээлэлийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах талаар үйлчлүүлэгчдийн ирүүлсэн санал.

- Хүлээлгийн танхимдаа бүх төрлийн худалдаа, үйлчилгээтэй баймаар байна - 46 үйлчлүүлэгч
- Байршил өөрчлөгдсөн мэдээлэл дутмаг - 10 үйлчлүүлэгч
- Шинэ байршилд нүүсэнтэй холбоотойгоор өмнөх драгон төвд очсон, хашаа нүүсэн мэдээллийг сайн түгээх - 6 үйлчлүүлэгч
- Хүлээлгийн танхимын орчинг өшөө сайн тохижуулах мэдээллийн самбарыг нэмж байршуулах - 5 үйлчлүүлэгч
- Тээш хадгалах газраа сайжруулах - 5 үйлчлүүлэгч
- Одоохондоо болж байна. Мэдээлэл сайн өгөх хэрэгтэй байна. Андуурч Номин худалдааны төв дээр очсон - 3 үйлчлүүлэгч
- Үйлчилгээний танхимд ус буцалгагч хэрэгтэй байна - 1 үйлчлүүлэгч



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 29 ДҮГЭЭР ХОРООНЫ ОРШИН СУУГЧДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Зорчигч тээврийн төв нь “Номин худалдааны төв” рүү нүүснээр аюулгүй оршин суух, зорчих, орчин нөхцөл сайжирсан эсэхийг тодорхойлох зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хорооны 23А, 23Б, 23В, 23Г, 24-р байрны оршин суугчдаас Google Forms ашиглан 2023 оны 09 дүгээр сарын 14-нөөс 18-ны хооронд судалгааны мэдээллийг цуглуулсан. Нийт 750 өрхөөс төлөөлөх чадвартай 118 өрх судалгаанд хамрагдсан болно.

1. ДРАГОН ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ОЙР ОРЧМЫН ОРШИН СУУГЧДЫН АМЬДРАХ ОРЧИНД ӨӨРЧЛӨЛТ ГАРСАН ЭСЭХ ТАЛААРХ САНАЛ АСУУЛГА




1.1 Зорчигч тээврийн төвийн байршил өөрчлөгдсөнөөр таны амьдрах орчин, аюулгүй байдал сайжирсан эсэх. $n=118$

Үүнээс 99.2% буюу 117 оршин суугч “Тийм” оршин суух орчин нөхцөл сайжирсан, 0.8% буюу 1 оршин суугч “Үгүй” хэмээн хариулсан байна.



2. ДАРААХ ШАЛГУУР ТУС БҮРТ 1-ЭЭС 5 ОНОО ӨГЧ ҮНЭЛНЭ ҮҮ.



2.1 Замын түгжрэл багассан эсэх. $n=118$


Нийт судалгаанд оролцогчдын 81 буюу 69% сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн нь түгжрэл буурсан гэж үзэж байна.



2.2 Хөл хөдөлгөөн, дуу чимээ багассан эсэх. $n=118$




Нийт судалгаанд оролцогчдын 83 буюу 70% сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн нь хөл хөдөлгөөн, дуу чимээ багассан хэмээн үзжээ.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 29 ДҮГЭЭР ХОРООНЫ ОРШИН СУУГЧДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН



2.3 Орц, гарц, машины зогсоолын хүрэлцээ сайжирсан эсэх. $n=118$




Нийт судалгаанд оролцогчдын **77** буюу **65%** сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.




2.4 Согтуу хүмүүс багассан эсэхэд $n=118$


Нийт судалгаанд оролцогчдын **63** буюу **53%** сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



2.5 Амьдрах орчны аюулгүй байдал сайжирсан эсэхэд. $n=118$



Нийт судалгаанд оролцогчдын **74** буюу **63%** сэтгэл хангалуун буюу **МАШ САЙН** болон **САЙН** гэж үнэлсэн байна.



3. САНАЛ, ХҮСЭЛТ

Сонгинохайрхан дүүргийн 29-р хорооны буюу Драгон төвийн ойр орчмын оршин суугчид зорчигч тээврийн нүүлгэсэнд дараах санал сэтгэгдлийг ирүүлсэн байна. Үүнд:

1. Нүүсэн нь маш зөв - **5 оршин суугч /**
2. Автотээвэр нүүснээр хүүхдүүд сургуульд явах орчин нөхцөл сайжирсан - **1 оршин суугч**
3. Автотээвэр нүүснээр түгжрэл багассан - **1 оршин суугч**
4. Автотээвэр нүүснээр оршин суугчдын тайван байдал сайжирсан - **1 оршин суугч**
5. Хулгайн тээвэр хийж байгаа жижиг тэрэгнүүдийг хязгаарлаж өгөөрэй - **4 оршин суугч**
6. Драгон зорчигч тээврийн төв байхад түгжрэл их мөн оршин суугчид болон хүүхдүүдийн аяулгүй байдал зөрчигдөж байсан харин зорчигч тээвэр нүүснээр хүүхдүүд аяулгүй хичээл сургуульдаа явах боломжтой болж байна. Тиймд Драгон зорчигч тээврийн төвийг бүр мөсөн хотын захруу нүүлгэн шилжүүлж өгнө үү - **1 оршин суугч**

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийн байршил “Номин худалдааны төв” рүү нүүж ирснээр аюулгүй үйлчлүүлэх орчин нөхцөл сайжирсан эсэхийг тодорлуулахад нийт судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн **79%** буюу **270** үйлчлүүлэгч **“Тийм”** сайжирсан хэмээн хариулсан байна.

Мөн Зорчигч тээврийн үйлчилгээний орчин нөхцөл, үйлчилгээтэй холбоотой 5 шалгуур үзүүлэлт тус бүрийг 1-5 оноогоор үнэлүүлсэн бөгөөд үзүүлэлт тус бүрт **“Маш сайн - 5 оноо”**, **“Сайн – 4 оноо”**-р үнэлэгдсэн нь байршил сольсноор автомашины зогсоол, хүлээлгийн танхим, нойлын хүрэлцээ зэрэг орчин нөхцөл сайжирснаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн 25% буюу 84 үйлчлүүлэгч санал хүсэлт ирүүлсэн. Эдгээр саналын дийлэнхи нь “Хүн орж гарах хаалга ганцхан мөн гадна торон хашааг буулгах тойрч гарч ачаа бараагаа холуур зөөх”, “Авто зогсоолоос автобусны зогсоол руу орох явган хүний хаалга гаргах”, “Урд талын авто замыг өргөтгөх, “Худалдаа үйлчилгээний төвийг нэмэгдүүлэх” гэх мэт саналыг ирүүлсэн. Тиймээс цаашид эдгээр үзүүлэлт болон бусад саналыг үйлчилгээндээ тусгаж ажиллах нь зүйтэй.

Судалгаанд хамрагдсан нийт оршин суугчдын 99.2% нь Сонгинохайрхан зорчигч тээврийн төвийг нүүлгэснээр амьдрах орчин, аюулгүй байдал сайжирсан энэ шийдвэрийг дэмжиж байна гэж хариулжээ. Мөн замын түгжрэл буурсан, согтуу хүмүүс багссан зэрэг санал сэтгэгдэл ирүүлсэн байна.

Төгсөв.